

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар
Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот
Хэлтсийн дарга Ж.Бумтуяа
Эмэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 01,02,03 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2026.03.27

Сургалт арга зүйн хэлтэс нь 2026 оны 01 дүгээр сард 4 зорилтын хүрээнд ажлын төлөвлөн ажилласан ба томоохон ажлын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тайлагнаж байна.

1. ХӨГЖИЛ ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Салбарын цахим хуудас болон удирдах ажилтнуудын долоо хоног бүрийн уулзалтаар мэдээлэл солилцоог зохион байгуулж, 59 байгууллагад мэдээлэл, зөвлөмж, чиглэлийг хүргэн удирдлагаар ханган ажиллав.

2. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

ОРОН НУТГИЙН ТӨРӨЛЖСӨН СУРГАЛТ: СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх хүрээнд нийт 32 цэцэрлэгийн 270 багш нарт сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг 2 өдөр цахимаар, 1 өдөр танхимаар зохион байгуулсан. Сургалтаар чадамжид суурилсан суралцахуйн үр дүнг тооцох, түүнийг өдөр тутмын сургалт үйл ажиллагааны төлөвлөлтийг оновчтой төлөвлөх арга зүйд хөтөлсөн. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашиглах 4 төрлийн арга зүйг уялдуулан зохион байгуулахад арга зүйн дэмжлэгийг тус тус хүргэж ажилласан.

Сургалтад нийт хөгжмийн багш 23, биеийн тамирын багш-16, бүлгийн-226 багш нар цахим болон танхимын сургалтад 100 хувь хамрагдсан. Сургалтыг МУИС-ийн Зүүн бүсийн салбар сургууль дээр 3 танхимд хүн бүрт хүртээмжтэй зохион байгуулж ажилласан.

"БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН МАМЛААД" НУТБЫН ТЭГҮҮНЭГ ГЭЖЛЭГД		
"БАГШЛАХУЙЦ ДЭМЖЭЖ ҮЗҮҮГЭЖ АРГА ЗҮЙ" СУРГАЛТЫН ХӨНӨӨР		
№	Хөгжлийн агуулга	Хугацаа
1	Сургалтын хөтөлбөр, сургалтын зорилго, үр дүн	4 цаг
2	Бүлгийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт, өдөр тутмын төлөвлөлт зэрэг нь	6 цаг
3	Шинэчилсэн сургалт, төлөвлөлт, сургалтын зорилго, үр дүн, хөгжлийн агуулга	4 цаг
4	Зөвлөмж, сургалтын зорилго, үр дүн, хөгжлийн агуулга	4 цаг
5	Төлөвлөлт, сургалтын зорилго, үр дүн, хөгжлийн агуулга	4 цаг



ОРОН НУТГИЙН ТӨРӨЛЖСӨН ЦАХИМ СУРГАЛТ: ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ

Ерөнхий боловсролын багш нарын цахим сургалт 2026 оны 01 дүгээр сарын 05-19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд судлагдахуун бүрээр 14 цахим анги үүсгэн ажилласан. Сургалтын үр дүнд ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд дижитал технологи, цахим сургалтын хэрэгслийг сургалтын үйл ажиллагаанд ашиглах талаарх мэдлэг, ойлголт, хандлагад тодорхой ахиц гарсан байна. Багш нар сургалтын явцад танилцуулсан цахим платформ, программ хангамж, ухаалаг хэрэгслийг сургалтын зорилго, агуулгад нийцүүлэн ашиглах боломжийг биечлэн туршиж, практик дадлагаар баталгаажуулсан нь сургалтын гол үр дүн болж байна.

Эх сурвалж: Дорнод аймгийн Боловсролын газар
Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот
Хэлтсийн дарга Ж.Бумтуяа
Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

Сургалтын явцад багш нарын дунд албан ёсны @medle.mn болон @moes.edu.mn цахим шуудангийн хэрэглээ жигд бус байгаа нь тодорхой ажиглагдлаа. Ялангуяа бага ангийн багш нарын хувьд цахим шууданг өдөр тутмын ажилдаа тогтмол ашигладаггүй, улмаар албан ёсны хаяг, нууц үг, нэвтрэх тохиргоотой холбоотой хүндрэлүүд түгээмэл гарч байв. Үүнээс шалтгаалан сургалтын платформд нэвтрэх, цахим ангид оролцох, даалгавар хүлээн авах, илгээх зэрэг энгийн үйлдлүүд дээр саатал үүсэж байгааг сургалтын явцад тодорхойлов.

Танхим болон цахим сургалтад оролцогчдын тоон мэдээлэл:

№	Мэргэжил	Нийт багшийн тоо	Сургалтад хамрагдсан багшийн тоо	Батламж авсан багшийн тоо /70 хувиас дээш гүйцэтгэлтэй багш нарт олгов/
1	ЕБС-ийн удирдах ажилтан	75	0	0
2	Монгол хэл, бичиг, уран зохиол	90	84	81
3	Математик	61	61	61
4	Физик	21	21	20
5	Хими	27	27	23
6	Биологи, эрүүл мэнд	26	24	21
7	Биеийн тамир	62	59	57
8	Хөгжим	29	26	25
9	Бага боловсрол	295	276	266
10	Дизайн технологи	55	55	52
11	Англи хэл	90	87	87
12	Орос хэл	24	24	21
13	Түүх, нийгмийн ухаан	76	72	72
14	Газарзүй	13	13	13
15	Мэдээллийн технологи	23	23	23
16	СӨБ-ын багш	270	270	265
17	СӨБ-ын удирдах ажилтан	62	0	0
	Нийт	1269	1122	1087

Сургалтын үеэр идэвхгүй байгаа цахим хаягуудын жагсаалтыг нэгтгэн, холбогдох байгууллагад хүргүүлж, бодит арга хэмжээ авч ажилласан нь сургалтын зохион байгуулалтын хувьд чухал алхам болсон. Мөн багш нарын дунд тохирох веб хөтөч (browser) сонгох, платформын үндсэн тохиргоо хийх, нууц үгээ сэргээх зэрэг дижитал суурь ур чадварын ялгаа байгааг илрүүлсэн нь цаашид шаталсан, түвшин ялгасан сургалт зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

Сургалтаар танилцуулсан Mentimeter, Google Classroom, Gemini, mozaWeb, mozaBook зэрэг программ, хэрэгслүүдийн талаар багш нар ерөнхий ойлголттой болсон бөгөөд зарим багш нар эдгээрийг сургалтын явцад шууд туршин ашиглаж, хичээлийн төлөвлөлт, үнэлгээ, сурагчийн оролцоог нэмэгдүүлэхэд үр дүнтэй болохыг онцолж байв. Гэсэн хэдий ч ихэнх багш нарын хувьд эдгээр программ, хэрэгслийг тогтмол хэрэглээ болгох дадал хараахан бүрэн төлөвшөөгүй, анхан шатны түвшинд ашиглаж байгааг сургалтын үр дүн харууллаа.

Мөн сургалтаар багш нар боловсролын цахим шилжилтийн хүрээнд өөрийн дижитал ур чадварыг бие даан хөгжүүлэх, шинэ программ, аппликейшнийг сургалтын үйл

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар

Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот

Хэлтсийн дарга Ж.Бумтуяа

Эмэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

ажиллагаанд нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатайг ухамсарласан нь чухал үр дүн гэж үзэж байна. Багш нарын дунд технологийг “нэмэлт ачаалал” бус, харин хичээлийн чанар, сурагчийн идэвх, суралцахуйн үр дүнг дэмжих “туслах хэрэгсэл” гэж ойлгох хандлага нэмэгдсэн нь сургалтын зорилготой бүрэн нийцсэн ахиц юм.

Иймд тус сургалт нь багш нарын дижитал чадамжийг бодитоор нэмэгдүүлэхийн зэрэгцээ цахим болон хосолсон сургалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай суурь мэдлэг, хандлага, практик ур чадварыг төлөвшүүлэхэд үр дүн өгсөн гэж дүгнэж байна.

БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ НАРЫН СПОРТЫН ТЭМЦЭЭН:

Эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх багш нарын уялдаа холбоог сайжруулах, хамтран хөгжсөн байна. Дорнод аймгийн бага боловсролын багш нарын чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг түгээх зорилго бүхий "Эрч хүч-ээрэг хандлага" спортын 3 төрөлт тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 25 сургуулийн 18 багийн 300 гаруй тамирчид ур чадвар, хурд хүчээ сорин өрсөлдлөө. Багийн дүнгээр 1-р байранд Хан-Уул сургууль, 2-р байранд 1 дүгээр сургууль, 3-р байранд 5 дугаар сургууль шалгарлаа. Тэмцээнийг хамтран зохион байгуулсан 2, 8 дугаар сургууль, Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерүүд хамтран зохион байгууллаа.



Тэмцээний явцаас

ЦЭЦЭРЛЭГИЙН АРГА ЗҮЙЧДИЙН СУРГАЛТ: Сургуулийн өмнөх боловсролын эрх зүйн баримт бичигтэй танилцах, дүн шинжилгээ хийх, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, арга зүйч нарын онол, арга зүй, ур чадвар, манлайллыг нэмэгдүүлэхэд цогц мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн энэхүү сургалтаар “Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажллагаа зохион байгуулах журам” “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр”, “Хүүхдийн цэцэрлэгийн арга зүйчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага” нийт 6 эрх зүйн баримт бичгийг судлан хэрэгжилтийг хангах, анхаарах асуудлыг тодорхойлж хамтын оролцоотой суралцсан. Энэхүү сургалтад 32 цэцэрлэгийн 35 арга зүйч, 7 эрхлэгч нийт 42 арга зүйч, эрхлэгч нар хамтран суралцсан. Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн шинэчлэл, бодлогын хэрэгжилтийн уялдааг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлж, удирдлагын чадавх нэмэгдсэн. Багаар ажиллах ур чадвар, чадамжид суурилсан баг бүрдүүлж ажиллах, манлайлах ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх зэрэгт суралцсан үр дүнтэй сургалт зохион байгуулагдсан.

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар
Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот
Хэлтсийн дарга Ж.Бумтуяа
Эмэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832



Сургалтын явцаас

ХООЛ ЗҮЙЧ, ТОГООЧ НАРТ МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАХ СУРГАЛТ:


Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор "Хоол үйлдвэрлэлийн бэлэн байдал ба эрүүл ахуй" сэдэвт нэгдсэн сургалтыг сургуулийн хоол зүйч нартай хамтран зохион байгуулав. Сургалтад хоол үйлдвэрлэлийн нийт 80 албан хаагч танхим болон цахим хэлбэрээр идэвхтэй хамрагдлаа.



Сургалтын явцаас

БАГА АНГИЙН “ЦАХИМ АЯЛАЛ” ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА, АРГА ЗҮЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ СУРГАЛТ:

Бага ангийн цахим контентын агуулга, арга зүйг түгээн дэлгэрүүлэх орон нутгийн сургалтыг 2026 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Сургалтад 95 багш танхимаар хамрагдлаа. Сургалтаар бага боловсролын математик, монгол хэл, хүн ба нийгэм, хүн ба орчин, хүн ба байгаль хичээлүүдийн интерактив контентын агуулга, арга зүй, суралцахуйн зорилтоо шинжилж, даалгавар гүйцэтгэх аргачлалд суралцаж, интерактив контент ашиглан ээлжит хичээлийн арга зүйн санаа боловсруулж харилцан туршлагаа солилцлоо.



“Цахим аялал” сургалтын явцаас

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар
Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот
Хэлтсийн дарга Ж.Бумтуяа
Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

МАТЕМАТИКИЙН МЭРГЭЖЛИЙН БАГШ НАРЫН БҮЛГИЙН АЖИЛ:

Математикийн мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Сурагчдад математикийн хичээлээр дамжуулан байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлын тухай ойлголт өгөх, бодит асуудлыг математик загварчлал ашиглан шийдвэрлэх арга зүйг багш нарт эзэмшүүлэх, туршлага солилцох зорилгоор математикийн мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагааг Хэрлэн сумын 2 дугаар сургуультай хамтран 2026.01.26-ны өдөр тус сургууль дээр зохион байгуулж, танхимаар 28 багш оролцож, сумдын багш нарт “Дорнод аймгийн математикийн багш нар” бүлгэмд лайваар дамжуулан хүргэлээ. Багш нарын мэргэжлийн бүлгийн үйл ажиллагаагаар: Математикийн хичээлийг зөвхөн томьёо бус, амьдрал дахь тогтвортой хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэх хэрэгсэл болгон заах шинэлэг арга зүйг туршлаа. Лайв дамжуулалт ашиглан сумдын багш нарт зайн сургалтын боломж олгосон нь цаг хугацаа, зардал хэмнэсэн үр дүнтэй ажил боллоо. Мөн Тогтвортой хөгжлийн боловсролыг математиктай холбож байгаа нь сурагчдын амьдрах ухаан, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байлаа.

Түүх, Нийгмийн ухааны багш нарын хичээл, үйл ажиллагааны арга туршлагыг бусдад түгээх, бусдаас суралцуулах, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжихэд чиглэсэн МБНБ-ийн ажлыг ерөнхий боловсролын 3 дугаар бүсийн сургуулийн багш нар Хөлөнбуйр сумын ЕБС-д зохион байгуулав. МБНБ-ийн ажилд танхимаар 44 багш, цахимаар 13 багш оролцов.



Судалгаат хичээлийн явцаас

ОНЫ ШИЛДЭГ ИЛТГЭЛ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААН:

Боловсрол, сургалт, хүүхэд хөгжүүлэх олон талт үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахад эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг оролцоо, практик туршлага, үр дүнг онол арга зүйн үндэстэй гарган тавьсан үндэсний тэргүүлэх үр дүнг хэлэлцэхэд чиглэх зорилгоор сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын 2025-2026 оны хичээлийн жилийн аймгийн шилдэг илтгэл шалгаруулах “БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛД ЭЦЭГ ЭХИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын II шат 01 дүгээр сарын 28-ны өдөр Халхгол сумын Ялалт багийн сургууль 100 жилийнхээ ойн хүрээнд Боловсролын газартай хамтран зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хуралд аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 5 бүсийн -10, мэргэжлийн боловсролын 2 илтгэл, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 5 бүсийн 10 илтгэлийг хэлэлцүүлсэн. Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэг, Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн илтгэл улсын уралдаанд оролцох эрх авлаа. Эрдэм шинжилгээний хурлын

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар

Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот

Хэлтсийн дарга Ж.Бумтуяа

Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

зочин шүүгчээр МУИС-ийн Зүүн бүсийн сургуулийн оюутны хөгжлийн хэлтсийн дарга, доктор Н.Баярмаа уригдан оролцлоо.



Боловсролын газар, Эрүүл мэндийн газрын хамтарсан удирдамжаар дэмжлэгт хяналтын 3 баг Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудаар Улаанбурхан өвчний голомтлон гарахаас урьдчилан сэргийлж хариу арга хэмжээг эрчимжүүлэх, халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах, шинж тэмдгийн тандалтыг хэрхэн хийж буй байдалд дэмжлэг хяналт хийж ажиллав.



Дэмжлэгт хяналтын баг сургуулийн үйл ажиллагаатай танилцах явцаас

ХАМТЫН АЖИЛЛАГАА:

Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллагын Дорнод орон нутгийн хөтөлбөрийн зохицуулагч Г.Ариунзаяа, А.Мөнхжин, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын мэргэжилтэн Ө.Одгэрэл нартай хамтран хүүхдийн эрхийг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, шуурхай тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Гэрээр айлчлагч” бэлтгэх 2 дахь шатны сургалтыг амжилттай зохион байгууллаа. Тус сургалтад сургуулийн өмнөх боловсролын 4 багш, Политехникийн коллеж, ерөнхий боловсролын 18 нийгмийн ажилтан хамрагдлаа.



Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар

Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот

Хэлтсийн дарга Ж.Бумтуяа

Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

Сургагч багш бэлтгэх сургалтын явцаас

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ 2026 ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ-3, ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

Элсэлтийн шалгалтын 3 дахь сорилыг 10 хичээлээр зохион байгуулсан. Уг шалгалтад 2962 суралцагч шалгуулав. Математик- 789, монгол хэл бичиг 295, англи хэл 658, орос хэл 3, нийгмийн ухаан 631, физик 249, биологи 149, хими 153, газарзүй 21, түүх 14 суралцагч хамрагдсан. 12-р ангийн Биологийн хөндлөнгийн үнэлгээнд 17 сургуулийн 175 суралцагч хамрагдлаа. Гүйцэтгэлийн дундаж 32.48 хувьтай байна.

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 02 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2026.03.02.

Сургалт арга зүйн хэлтэс нь 2026 оны 02 дугаар сард 4 зорилтын хүрээнд ажлыг төлөвлөн ажилласан ба томоохон ажлын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тайлагнаж байна.


2. ХӨГЖИЛ ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Салбарын цахим хуудас болон удирдах ажилтнуудын уулзалтаар мэдээлэл солилцоог зохион байгуулж, 59 байгууллагад мэдээлэл, зөвлөмж, чиглэлийг хүргэн удирдлагаар ханган ажиллав.

2. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТ:

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалт, үйл ажиллагааны чанарыг үнэлэх, хяналт-шинжилгээ хийх арга зүй шинэчлэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор орон нутгийн хэмжээнд цэцэрлэгийн эрхлэгч нарт зориулсан “Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журам”-ыг танилцуулах арга зүйн сургалт зохион байгуулагдлаа. Сургалтад хамрагдсан эрхлэгч нар цаашид авсан мэдлэгээ өөрийн цэцэрлэгийн багш, ажилчдад түгээн дэлгэрүүлж, үнэлгээний шинэ журмыг практикт хэрэгжүүлж эхлэх юм. Ингэснээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанар сайжирч, хүүхэд хөгжих таатай орчин бүрдэх, эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо томоохон түлхэц болно.



Сургалтын явцаас

**ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЖИЛТНУУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛЛАА.**

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар

Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот

Хэлтсийн дарга Ж.Бумтуяа

Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор "Хоол үйлдвэрлэлийн бэлэн байдал ба эрүүл ахуй" сэдэвт сургалтыг хоол зүйч нартай хамтран зохион байгууллаа. Сургалтад хоол үйлдвэрлэлийн нийт 38 албан хаагч танхим болон цахим хэлбэрээр идэвхтэй хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлээ.

“Хүүхдийн хоолны цэс төлөвлөлтөд анхаарах асуудлууд”, “Хоол үйлдвэрлэлийн өнгөний систем”, “Хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдийн хооллолтыг дэмжих нь”, “Эрүүл ахуй, ажиллагсдын хувийн ариун цэвэр, эрүүл мэндийн шаардлага”, “Аюулгүй хоол хүнс бэлтгэх технологи” гэсэн сэдвүүдээр сургалтыг дараах сэдвийн хүрээнд зохион байгуулж, санал солилцож ажиллалаа.



Сургалтын явцаас

УРАН ХӨДӨЛГӨӨНТ ГИМНАСТИКИЙН 2026-2028 ОНЫ ЗААВАЛ ХИЙХ ДАСГАЛ” – ЫН СУРГАЛТ:

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын биеийн тамирын болон бүлгийн 64 багш хамрагдсан “Уран хөдөлгөөнт гимнастикийн 2026-2028 оны заавал хийх дасгал” – ын сургалт, дадлага амжилттай боллоо.

Багш нар шинэчилсэн дасгалын техникүүдийг практик хэлбэрээр эзэмшиж, хүүхдийн бие бялдрын хөгжлийг дэмжих шинэ арга зүйгээр хангагдлаа. Ингэснээр цэцэрлэгийн насны хүүхдүүд хөдөлгөөний эвсэл олгох, чийрэгжүүлэх гимнастикийн дасгалуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй, зөв техникээр гүйцэтгэх боломж бүрдэж байна.



Сургалтын явцаас

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар

Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот

Хэлтсийн дарга Ж.Бумтуяа

Эмэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

ФИЗИКИЙН БАГШ НАРЫН УУЛЗАЛТ:

Улсын физикийн олимпиадын хүрээнд Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат, Улсын физикийн олимпиадын хорооны дарга М.Ганбат нар Ерөнхий боловсролын сургуулийн физикийн багш нартай уулзалт хэлэлцүүлгийг дараах агуулгын хүрээнд зохион байгууллаа. Үүнд:

1. Боловсролын газраас физикийн боловсролын талаар мэдээлэл хийв.
2. Засаг даргын орлогч, аймгийн олимпиад зохион байгуулах ажлын хэсгийн ахлагч Ч.Ганбат олимпиадын зохион байгуулалтын талаар багш нарын санал, хүсэлтийг сонсож, хамтран ажиллах боломж, шийдлүүдийг хэлэлцлээ.
3. Олимпиадын хороон дарга гавьяат багш, доктор М.Ганбат аймгийн олимпиадад оролцох багийн гишүүдийн бэлтгэл сургалтыг чанартай хийхэд дэмжлэг үзүүлэх



Уулзалтын явцын хэсгээс

ДИЗАЙН ТЕХНОЛОГИЙН БАГШ НАРЫН МЭРГЭЖЛИЙН БҮЛГИЙН АЖИЛ:

Дизайн технологийн багш нарын МБНБ-ийн ээлжит үйл ажиллагаагаар багш нарын онол арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх, төсөл боловсруулах чадварыг хөгжүүлэх зорилготойгоор танхим болон цахим хосолсон хэлбэрээр явагдаж, нийт 48 багш идэвхтэй хамрагдлаа.

МУБИС-ийн багш, Боловсрол судлалын Ph.D (Доктор) Г.Чулуунаа урилгаар оролцож, "Илтгэл болон төсөл бичих арга зүйн онол, практик зөвлөмж" сэдэвт цахим хичээлийг заав. Энэхүү хичээлээр багш нар эрдэм шинжилгээний ажил, төсөл бичихэд анхаарах гол асуудлуудын талаар мэдлэгээ дээшлүүллээ.

Сургалтын агуулгыг орон нутгийн онцлогт тохируулан хөрсөнд буулгах, заах арга барилыг амьдралд хэрэгжүүлэх талаар багш Б.Насанжаргал мэргэжил нэгт багш нарт зөвлөгөө өгч, туршлагаасаа хуваалцав.



Мэргэжлийн багш нарын бүлгийн ажлаас

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар

Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот

Хэлтсийн дарга Ж.Бумтуяа

Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

ЗАХИРЛУУДЫН МЭРГЭЖЛИЙН БҮЛГИЙН АЖИЛ

Ж.Болормаа ахлагчтай ЕБС-ийн 2 дугаар бүс захирлуудын мэргэжлийн бүлгийн ажлыг 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгууллаа.

Мэргэжлийн бүлгийн хамтдаа хөгжих үйл ажиллагаанд аймгийн төвийн 1, 2, 5, 8 11, 12, Шинэ хөгжил, Хан-Уул, Дорнод ахлах, Flower сургуулийн захирлууд танхимаар Баяндун, Халхгол, Булган, Гурванзагал, Дашбалбар, Хөлөнбуйр, Сэргэлэн, Ялалт багийн ЕБС-ийн захирлууд онлайнаар оролцов. Мэргэжлийн бүлгийн ажлаар “Зорилготой хүүхэд” дэвтэр хөтлүүлсэн сайн туршлага, “Стресс менежмент”-ийн сургалт дадлага ажил, “Хүүхдэд ээлтэй ментор багш” хөтөлбөрийн танилцуулга хийгдэж, төв сургуулийн сургалтын орчинтой танилцаж, суралцагчдын байгалийн ухааны хичээлийн үзэсгэлэнг сонирхож хамтран суралцлаа.



Мэргэжлийн бүлгийн явцаас

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БАГШ НАРЫН МЭРГЭЖЛИЙН БҮЛГИЙН АЖИЛ:

Мэдээллийн технологийн багш нарын бүлгийн ажлаар багшийн заах арга зүйг боловсронгуй болгох, сурагч бүрийн суралцах онцлогт тохирсон “Ялгаатай даалгавар”-ыг нэвтрүүлсэн арга зүй, туршлагаа хуваалцсан нь онцлогтой байлаа. Бүлгийн ажилд танхимаар танхимаар 12 багш, цахимаар 9 багш хамрагдан, “Ялгаатай даалгавар” сургалт, мэдээлэл, Мэдээллийн технологи - Ганцаарчилсан хөтөлбөр, “Баримтад нүүр хуудас хийх” нээлттэй хичээл, “Бичвэр боловсруулах” нэгж хөтөлбөр (VARK), “Алгоритм” нэгж хөтөлбөр, Ялгаатай даалгавар, “Canva Education боломжууд” сургалт, үйл ажиллагааны үр дүн хэрэгжүүлсэн туршлагаа түгээн дэлгэрүүллээ.

Багшийн арга зүйд гарсан ахиц: Сурагч бүрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөг “чиглүүлэгч” болж өөрчлөгдсөн. Canva болон AI технологи ашиглан сургалтын хэрэглэгдэхүүнээ боловсруулж, “Алхам алхмаар” гарын авлагаар туршлагаа системчилсэн. Сурагчдын бүтээлийг бодитой үнэлж, өөрийн үнэлгээний аргыг нэвтрүүлэв. Ялгаатай даалгавар болон VARK арга зүйг нэвтрүүлсэн нь анги танхимд тэгш хамруулах боловсролын зарчмыг бодитоор хэрэгжүүлж, сургалтын чанарыг ахиулсан бодит үр дүнтэй ажил боллоо. Энэхүү туршлагаа бусад багш нарт түгээн дэлгэрүүлснээр:

- Багш нар харилцан туршлага солилцож, “Хүүхэд бүрийг хөгжүүлэх” нэгдсэн арга зүйн хэлцэлд хүрлээ.
- Дижитал болон биет хэрэглэгдэхүүнийг сурагчийн танин мэдэхүйн онцлогт тохируулан системчилснээр хичээлийн бэлтгэл хангахад зарцуулах цаг хугацааг хэмнэх боломж бүрдлээ.

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар
Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот
Хэлтсийн дарга Ж.Бумтуяа
Эмэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832



Мэргэжлийн багш нарын бүлгийн ажлаас

ОРОС ХЭЛНИЙ МЭРГЭЖЛИЙН БҮЛГИЙН АЖИЛ БОЛЛОО

Аймгийн орос хэлний багш нарын мэргэжлийн бүлгийн ажил хуваарийн дагуу энэ хичээлийн жилийн 3 дахь ажил 02 дугаар сарын 11-ний өдөр 3 дугаар бүсийн Баянтүмэн ерөнхий боловсролын сургуульд боллоо. Мэргэжлийн бүлгийн ажилд аймгийн 12 сургуулийн 18 багш танхимаар, сумдын багш нар онлайнаар оролцсон.

Мэргэжлийн багш нарын бүлгийн ажлаар Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн багш П.Батсайхан “Что ты любишь есть, пить?” сэдвээр 7 дугаар ангид хичээл зааж арга зүй, туршлагаа түгээж, хэлэлцүүлэг хийн хичээлийн төлөвлөлтийг суралцахуйн зорилт, суралцахуйн үр дүн, шалгуурт уялдуулан төлөвлөж, сурагчдыг ажлын хуудас, AI хэрэглэгдэхүүнээр чиглүүлэн, иэдвхтэй сургалтын аргааг оролцоог хангасан хичээл болсон гэж дүгнэлээ.

Мөн Баянтүмэн сургуулийн багш Н.Бадамханд “Тоглоомын арга зүй”, Дашбалбар сургуулийн багш Ө.Ундрал “Цахим платформыг үнэлгээнд ашиглах нь” сэдвээр сайн туршлагаа хуваалцаж, Хөлөнбуйр сургуулийн захирал Ө.Ганзул “Багшийн албан тушаалын тодорхойлолт дахь үйл ажиллагаа” танилцуулга мэдээлэл хийн багш нар идэвхтэй сургалтын арга зүй, албан эрх зүйн мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

Боловсролын газар, Дэлхийн зөн Монгол олон Улсын байгууллагын Дорнод орон нутгийн хөтөлбөртэй хамтран ажиллах 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө баталлаа. Хамтын ажиллагааны хүрээнд: 1. Эцэг эх, асран хамгаалагч, орон нутгийн иргэд хүмүүжлийн эерэг арга, хүүхэд хамгааллын асуудлуудаар (хүчирхийлэл, мөлжлөг, хүүхэд худалдаалах, хүүхдийн хөдөлмөр, цахим аюулгүй орчин) сургалт нөлөөллийн үйл ажиллагаа

2. Хүүхэд, өсвөр үеийнхэн амьдрах ур чадвараа үр дүнтэйгээр дээшлүүлэн, үйл ажиллагаа санаачилж шийдвэр гаргах түвшинд оролцох боломжтой болсон байна, Өсвөр үеийнхний эерэг, эрүүл шийдвэр гаргах мэдлэг сайжруулах

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар

Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот

Хэлтсийн дарга Ж.Бумтуяа

Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

3. Орон нутгийн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүд, тэдний гэр бүлд чиглэсэн олон нийтэд суурилсан үйлчилгээгээр дамжуулан мэдээлэх, холбон зуучлах механизмыг бэхжүүлэх

4. Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт бүртгэлтэй хүүхдүүдийн стандарт үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

5. Тусгай хэрэгцээт хүүхдийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана.



бүлгийн 1957 суралцагчаас 1842 суралцагч оролцож, 112 суралцагч оролцоогүй ба 78.8 хувийн гүйцэтгэлтэй. 3 дугаар ангийн “Математик” хичээлийн хөндлөнгийн үнэлгээнд 62 бүлгийн 1957 суралцагчаас 1796 суралцагч оролцож, 118 суралцагч оролцоогүй ба 76.8 хувийн гүйцэтгэлтэй.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, зөвлөн туслах үйл ажиллагааны удирдамжийн дагуу 2026 оны 02 дугаар сарын 05, 26-ны өдөр Хэрлэн сумын ерөнхий боловсролын 11, Хан-Уул сургуульд зөвлөн тусалж, арга зүйн дэмжлэг үзүүллээ. Ажиллах хугацаандаа 81 багшийн хичээлд сууж, давхардсан тоогоор 177 багш, удирдах ажилтанд ганцаарчилсан зөвлөгөөг өгч, 156 багш, удирдлага, ажилтны бичиг баримт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй танилцав. Сургуулийн удирдах ажилтны манлайлал, хамт олны хандлагыг тандах асуулгыг 101 албан хаагчаас, боловсролын багц хуулийн талаарх тандалт судалгаанд 113 багш, удирдах ажилтныг хамрууллаа.

"ӨВ СОЁЛ ХАМТДАА УНШЪЯ" АЯН ЗОХИОН БАЙГУУЛАВ.

“Өв соёл-Хамтдаа уншъя” үйл ажиллагаанд нийт 31 цэцэрлэг 2-3 бичлэгийг өөрийн цэцэрлэгийн пэйж хуудсанд байршуулан нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Эх хэл, үндэсний өв соёлыг таниулах үйл ажиллагаанд 500 гаруй хүүхэд, бүлгийн багш, багшийн туслах, эцэг эх, асран хамгаалагч 320 гаруй төлөөлөл хамтран ажилласан.



“ГЭРТЭЭ ТУРШЪЯ АЯН” ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар

Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот

Хэлтсийн дарга Ж.Бумтуяа

Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

Суралцагчдын сорил туршилт, судалгаа шинжилгээ хийх чадварыг дээшлүүлэх шинжлэх ухааны туршилт бүхий оюуны бүтээлүүдийг урамшуулах, сурталчлах зорилго бүхий “Гэртээ туршья” аяныг 2026 оны 1-р сарын 01-30 ны хооронд зохион байгуулсан ба аянд Ерөнхий боловсролын 20 сургуулийн 2-11 дүгээр ангийн **1705** туршилтат контентийг **1860** хүүхэд хамтран хийж “Дорнод Эюрика” пэйж хуудсанд байршуулж, **1190 хүн** сэтгэгдэл үлдээж, **14597** хүн контентод хариу үйлдэл үзүүлж, **171701** хүн үзэж сонирхсон байна.

Тус аянд оролцсон суралцагчдын тоо 2025 онтой харьцуулахад 500-аар нэмэгдсэн. Баян-Уул сумын ЕБС-ийн 9б ангийн сурагчид Ц.Тэлмүүн, Д.Чимэгмаа “Ягаан байцааны навчисны өнгө” туршилт, Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 7г ангийн сурагч М.Билгүүдэй, Физикийн туршилт, Хэрлэн сумын 1 дүгээр сургууль 2д ангийн сурагч М.Билгүүнтамир “Ус яагаад асгарахгүй байна вэ?” туршилт хамгийн их хандалт авсан байна.

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 03 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2026.03.27.

Сургалт арга зүйн хэлтэс нь 2026 оны 03 дугаар сард 4 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг төлөвлөн ажилласан ба томоохон ажлын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тайлагнаж байна.

3. ХӨГЖИЛ ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Салбарын цахим хуудас болон удирдах ажилтнуудын 2 удаагийн уулзалтаар мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулж, 59 байгууллагад мэдээлэл, зөвлөмж, чиглэлийг хүргэн удирдлага, арга ханган ажиллав.

2. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Сургуулийн өмнөх боловсрол- цэцэрлэгийн багш болзолт уралдааны явцаас:

“Цэцэрлэгийн багш” болзолт уралдааны 2 дугаар шатны нэгдүгээр даалгавар багшийн бүтээлч сэтгэлгээний арга барил хэрэглэх, асуудал шийдвэрлэх чадварыг сорих сургалт, үйл ажиллагаа Хэрлэн сумын 6, 7, 11, 16, 17 дугаар цэцэрлэгт хэсгээр зохион байгуулагдаж, 1 дүгээр шатны шалгаруулалтад тэнцсэн 27 багш, 17 багшийн туслах оролцов.

Сургалт, үйл ажиллагааны онцлог нь шинэ үеийн хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн, хүүхдийн ялгаатай байдал, сурах үйлийг оновчтой чиглүүлж идэвхжүүлсэн сургалтыг зохион байгуулах, арга зүй туршлагаа хуваалцах, харилцан суралцах байлаа.

Нэгдсэн дүнгээр 60-аас дээш хувьтай 20 бүлгийн багш, 12 багшийн туслах дараагийн шатны шалгаруулалтад орох эрхээ авлаа.



Уралдааны явцаас

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар

Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот

Хэлтсийн дарга Ж.Бумтуяа

Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

ТЭРГҮҮЛЭХ БАГШИЙН МАНЛАЙЛАЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Боловсролыг дэмжих жилийн хүрээнд 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа бага боловсролын багш нараа чадваржуулах, заах арга зүйг нэмэгдүүлэх, зэрэгтэй багш нарын манлайллыг нэмэгдүүлж тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэн хамтран суралцлаа. Сургалт цахим орчин, хуудас бүхэн түүх, сэтгэл зүйн булан гэсэн 3 өртөөгөөр зохион байгуулагдаж, танхимаар ерөнхий боловсролын 18 сургуулийн багш нар хамрагдсан.

Сургалтад 34 багш танхимаар, 23 багш цахимаар, нийт 57 багш хамрагдан, 5 агуулгаар мэдээлэл авч, харилцан суралцсан үйл ажиллагаа болов.



Сургалтын явцаас

“Иргэний ёс зүйн боловсрол” мэргэжлийн багш нарын бүлгийн “Сайн хичээл-2026” ур чадварын уралдаан 2 үе шаттай зохион байгуулж, ерөнхий боловсролын 9 сургуулийн 29 багш оролцлоо.

Уралдаанд Хан-Уул сургуулийн багш Э.Анударь 1-р байр, 8 дугаар сургуулийн багш Э.Нандинцэцэг 2-р байр, Хан-Уул сургуулийн багш Б.Нямсүрэн 3-р байранд шалгарлаа. Багш нар сургалтын олон бүтээлч арга зүйг сургалтдаа туршиж, туршлага түгээсэн, багаар ажилласан, сурагчдад эзэмшүүлэх мэдлэг чадварыг хандлагыг илрүүлсэн даалгавар тусгасан байлаа.



Сургалтын явцаас

БАГШ, СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН СУРГАЛТ:

Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллагын Дорнод орон нутгийн хөтөлбөртэй хамтран Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны “Хүүхдийн эрхийг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай” 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг ханган, “Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын байгууллагын хүүхэд хамгааллын багаар дамжуулж хүүхдийн гэрээр айлчлах арга хэмжээ, суралцагчдын аюулгүй байдал, эрсдэлийг тандах судалгааг зохион байгуулж, хамгаалал шаардлагатай хүүхдүүдийг шуурхай тусламж үйлчилгээнд холбон зуучлах нөхцөлийг бүрдүүлж сум, багийн Хамтарсан багт дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах” мөн хүүхэд хамгааллын /урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, шуурхай тусламж/-ийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хамтдаа-хөгжье-оролцъё-хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг Хэрлэн сумын хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын 59 өрхийн 56 оролцогчдод “Сэтгэл зүйн боловсрол”, “Гэр бүлийн баяр хөөр, “Хүмүүжлийн эерэг арга” сургалтыг зохион байгууллаа.

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар
Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот
Хэлтсийн дарга Ж.Бумтуяа
Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832



Сургалтын явцаас

Монголын тусгай Олимпын хороотой хамтран зохион байгуулж буй Оюуны бэрхшээлтэй (Дауны хам шинж, Аутизмын хүрээний эмгэг, Тархины саажилт, Оюуны хоцрогдол IQ 70-аас бага) хүүхэд-залуус, насанд хүрэгчдийг урлаг, спортоор дамжуулж хөгжүүлэх, бие бялдрыг нь чийрэгжүүлэх, өөртөө итгэлтэй болох, нийгэмшүүлэх зорилготой “Бүжгийн багш дасгалжуулагч бэлтгэх” хүүхдийн 21 цэцэрлэг, ерөнхий боловсролын 5 сургуулийн нийт 26 багшийг хамруулж, хамтран ажиллалаа.



Сургалтын явцаас

Дорнод аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтран сонсгол хамгаалах дэлхийн өдрийг угтсан "Өнөөдөр хамгаалж, маргааш тод сонсьё" нэгдсэн арга хэмжээг Хэрлэн сумын 1, 2, 5, 8, 11, 12, Хан-Уул, Шинэ хөгжил, Дорнод ахлах сургууль тус бүрээс 9-12-р ангийн төлөөлөл нийт 75 сурагчдыг хамруулан зохион байгууллаа.



Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Дорнод орон нутгийн хөтөлбөр болон "Энэрлийн түүхээ" төрийн бус байгууллагатай хамтран хөгжлийн ялгаатай хүүхэдтэй ажиллаж буй багш нарыг чадваржуулах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор "Модуль-1" сургалтыг зохион байгууллаа. 2026 оны 3 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд цахимаар явагдсан тус сургалтад Хэрлэн сумын 1, 2, 5, 8, 11, 12 дугаар сургууль болон Хан-Уул, Шинэ хөгжил, Чойбалсан, Баянтүмэн сумын 105, хүүхдийн цэцэрлэгийн 20 нийт 125 багш хамрагдаж байна.

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар

Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот

Хэлтсийн дарга Ж.Бумтуяа

Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832



Сургалтын явцаас

МАТЕМАТИКИЙН МЭРГЭЖЛИЙН БАГШ НАРЫН БҮЛГИЙН АЖИЛ:

Математикийн багш нар хамтран суралцах замаар хичээлийн төлөвлөлтөд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, туршилт болон технологийн интеграцийг ашиглан сурагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх шинэлэг арга зүйг турших, сайн туршлагаа харилцан түгээхэд чиглэсэн. Суралцахуйд суурилсан сайн хичээлийг амжилттай зохион байгууллаа. 9-р ангийн "Цилиндр, конусын огтлолын талбай" сэдвээр "Шинэ хөгжил" сургуулийн математикийн багш Т.Ариунаа тэнхлэг огтлолыг цаасан модель болон 3D дүрслэл ашиглан сурагчдаар өөрсдөөр нь бүтээлгэх замаар хийсвэр ойлголтыг бодит болгож заав. 9-р ангийн "Excel ба Өгөгдлийн анализ" сэдвээр 8-р сургуулийн математикийн багш М.Оюунзул бодит өгөгдлийг Excel програм дээр боловсруулж, диаграмм бүтээх замаар технологийн интеграцийг хичээлд үр дүнтэй ашиглав. 12-р ангийн "Функц" сэдвийн хүрээнд тулгардаг ойлголтын зөрүүг арилгах чиглэлээр МУ-ын Зөвлөх багш Б.Гантөмөр зөвлөгөө өгч, багш бүр дараагийн хичээлдээ ашиглах шинэ арга барилд суралцав.



Мэргэжлийн багш нарын бүлгийн явцаас

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Боловсролын хууль тогтоомж, тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр хийж байгаа ажил, түүний үр дүн, сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжилт, үр дүнтэй танилцах мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх хүрээнд Хэрлэн сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгт Боловсролын газрын ахлах арга зүйч 8, эрхлэгч, арга зүйч 10 нийт 18 хүний оролцоотой ажилласан. Боловсролын сайдын 2025 оны А/37-р тушаалын хэрэгжилт болон мэдлэгийн сорил авч, хууль эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэхэд арга зүйн сургалтыг түгээн ажиллаж өөрийн үнэлгээ зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан байдалд зөвлөн арга зүйн дэмжлэг үзүүлсэн.



Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар

Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот

Хэлтсийн дарга Ж.Бумтуяа

Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

Мөн шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт агууллагын төлөвлөлт, сар, долоо хоноогийн төлөвлөлт, өдөр тутмын төлөвлөлтөд СҮД хоорондын уялдааг оновчтой төлөвлөж буй байдалд 5 бүлгийн багшийн өдөр тутмын чиглүүлэгтэй үйл ажиллагаа, хүүхдийн хөгжлийн үнэлгээ түүний баримт нотолгоо бүрдүүлэлт зэрэгт ажиглалт хийж зөвлөн ажилласан. Мөн мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагааны явцтай танилцан бичиг баримтын боловсруулалт, анхаарах асуудлыг тодорхойлон зөвлөн ажилласан.



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, зөвлөн туслах үйл ажиллагааны удирдамжийн дагуу 2026 оны 03 дугаар сарын 05, 12, 19-ны өдөр Хэрлэн сумын ерөнхий боловсролын 5, Түгээмэл оюун, 2 дугаар сургуульд зөвлөн тусалж, арга зүйн дэмжлэг үзүүллээ. Гурван сургуульд ажиллах хугацаандаа 76 багшийн хичээлд сууж, давхардсан тоогоор 172 багш, удирдах ажилтанд ганцаарчилсан зөвлөгөөг өгч, 151 багш, удирдлага, ажилтны бичиг баримт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй танилцав.



Хичээлийн явцаас

Сургуулийн удирдах ажилтны манлайлал, хамт олны хандлагыг тандах асуулгыг 70 албан хаагчаас, боловсролын багц хуулийн талаарх тандалтын сорилд 117 багш, удирдах ажилтныг хамрууллаа.



Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар

Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот

Хэлтсийн дарга Ж.Бумтуяа

Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

БАГШИЙН ТУСЛАХЫН СУРГАЛТ

Багшийн туслах нарын мэргэжлийн багш нарын бүлэгтэй хамтран ажлын байран дээр тасралтгүй хөгжих, цаг үеийн мэдээллээр ханган ажиллах хүрээнд “Боловсролын хөгжлийн манлайлал” ТББ-тай хамтран 40 цагийн сургалтыг цахим болон танхим хослуулан зохион байгууллаа. Энэхүү сургалтад 31 цэцэрлэгийн 224 багшийн туслах нар хамрагдсан. Сургалтыг 2026 оны 03 дугаар сарын 17,19-ны өдрүүдэд цахимаар, 2026,03,23-ны өдөр танхимаар,27-ны өдөр цахимаар тус тус зохион байгууллаа. Сургалтаар Багшийн туслахын ажлын байрны тодорхойлолт, хүүхэд хамгаалал, багшийн ёс зүй боловсролын талаарх эрх зүйн баримтын хэрэглээ, бүлгийн өдөр тутмын хуваарьт үйл ажиллагаанд багшийн туслахын оролцоо дэмжлэг, бага насны хүүхдийн хувийн ариун цэвэр, эрүүл ахуйн үйлд оролцоо дэмжлэг зэрэг сэдэвт сургалтыг нийт 220 гаруй багшийн туслах нарын саналд үндэслэн хөтөлбөрийн боловсруулан амжилттай зохион байгуулсан.



Сургалтын үйл явцаас

3.СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: АНГЛИ ХЭЛНИЙ “CROWN” БАГИЙН ОЛИМПИАД

Суралцагчдын англи хэлний мэдлэг, харилцааны чадвар, бүтээлч сэтгэлгээ, багаар ажиллах ур чадварыг хөгжүүлэх зорилготой Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн санаачилсан “Crown” англи хэлний багийн олимпиад нь 3 дахь жилдээ зохион байгуулагдлаа. Тус олимпиадад энэ жил 14 сургуулийн 6-11 дүгээр ангийн 87 багийн 522 сурагч оролцон 6 ангилалд англи хэлний мэдлэг оюунаа сорьж шилдгүүдээ тодрууллаа. Энэ жилийн олимпиадыг Чойбалсан хотын захирагчийн албаны дэмжлэгтэйгээр зохион байгуулсан ба суралцагчид сонсох, унших, ярих, хэрэглээний чадвараас гадна асуудал шийдвэрлэх, багаар ажиллах чадвараа хөгжүүлж, өөрсдийн авьяас, ур чадварыг нээн харуулах боломжийг олгов.



Олимпиадын үйл ажиллагаанаас

Улсын төрөлжсөн олимпиадын монгол бичгийн хичээлийн төрөл 2026 оны 3 дугаар сарын 2-5-ны өдөр Хэрлэн сумын 1-р сургуульд анги нийтийн, ганцаарчилсан, уншлага гэсэн 3 төрлөөр явагдаж, анги нийтийн 8-р ангийн төрөлд 17 сургуулийн 451 сурагч, 10-р анги төрөлд 18 сургуулийн 438 сурагч оролцсон.

Эх сурвалж:

Дорнод аймгийн Боловсролын газар
Сургалт арга зүйн хэлтэс, 207 тоот
Хэлтсийн дарга Ж.Бумтуяа
Емэйл: bumtuyaa5fvk@moes.edu.mn Утас: 99588832

Ганцаарчилсан мэргэжлийн багш төрөлд 36, бага ангийн багш төрөлд 31, 12-р ангийн сурагч төрөлд 27 сурагч оролцож тэргүүлсэн багш сурагчид улсад оролцох эрхтэй боллоо. Технологийн олимпиадын 9 төрөлд ерөнхий боловсролын 13 сургуулийн 100 сурагч, 47 багш хамрагдсан.



Олимпиадын үйл ажиллагаанаас

“МӨРӨӨДЛӨӨ МЭРГЭЖИЛ БОЛГОЁ” ӨДӨРЛӨГ

Дорнод аймгийн ахлах ангийн сурагчдадаа мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор “Мөрөөдлөө мэргэжил болгоё” өдөрлөгийг анх удаа зохион байгууллаа. Энэхүү өдөрлөгт ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Чита хотын төмөр замын дээд сургууль, Өвөр байгалийн хязгаарын хөдөө аж ахуйн их сургууль, Бүгд найрамдах Солонгос улсын нисэхийн коллеж, MOKWON их сургууль, Тэжин их сургууль болон Монгол улсын шилдэг их, дээд сургууль, коллежууд зэрэг 30 орчим дээд боловсролын байгууллагууд, аж ахуй нэгж байгууллагуудыг урьж оролцуулан цогц мэдээллийг өгч байгаа ба 13 сумаас нийт ахлах ангийн 5000 гаруй суралцагч эцэг эх, асран хамгаалагч, багш нарын хамт оролцож, мэдээлэл авлаа. Өдөрлөгийн үйл ажиллагаа болон мэдээлэл нь суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн эрэлт хэрэгцээг хангасан мэдээлэл боллоо хэмээн сэтгэгдэлдээ дурдсан байна.

**ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ:**

25 сургуулийн 4 дүгээр ангийн 62 бүлгийн 2072 суралцагчаас монгол хэл хичээлийн хөндлөнгийн үнэлгээнд 1986 суралцагч хамрагдан 71.3 хувь Математик хичээлийн хөндлөнгийн үнэлгээнд 1996 суралцагч хамрагдан 73.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

ТАЙЛАН БИЧСЭН: САЗХ-ИЙН ДАРГА Ж.БУМТУЯА